ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2026/004/НА-СТА-ТТЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2026 он


Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас:88883317 Цахим хаяг: Erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99089114 Цахим хаяг: Tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо

Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.03.25 № 01/317

танай __________ -ны № __________ -т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-ҮҮР СУМЫН ЗАСАГ
ДАРГА Т.ХАНДДОРЖ ТАНАА

### Хараат бус аудиторын дүгнэлт

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагаан-Үүр сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдлын нэгтгэсэн тайлан, санхүүгийн үр дүнгийн нэгтгэсэн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн нэгтгэсэн тайлан, мөнгөн гүйлгээний нэгтгэсэн тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн нэгтгэсэн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд үндсэн хөрөнгө 1,485.6 сая төгрөгөөр нэмэгдэхэд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Засаг даргын Тамгын газрын шинэ барилгыг үнэ төлбөргүй хүлээн авсан нь гол нөлөө үзүүлсэн байна.

#### Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй. Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ.Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитаар төсвийн төлөвлөлт, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 43.7 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлж, 2 зөвлөмж өглөө.

**Бусад асуудлын хэсэг**

Цагаан-Үүр сумын Засаг дарга нь аймгийн Засаг даргатай 2025 онд 6 зорилт, 133 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар гэрээ байгуулж, гэрээний хэрэгжилтийг 91.2 хувиар дүгнүүлсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2. Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

(мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | 1. ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 3,205,932.2 | 3,132,256.2 |
| 2 | 1.1.1 МӨНГӨН ХӨРӨНГӨ | 2,606,017.6 | 1,661,107.8 |
| 3 | 1.1.3 АВЛАГА | 42,701.59 | 163,549.6 |
| 4 | 1.1.5 БАРАА МАТЕРИАЛ | 557,213.1 | 1,211,869.7 |
| 5 | 1.1.6 НӨӨЦИЙН БАРАА | 0.0 | 95,729.0 |
| 6 | 1.2 ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,757,219.8 | 3,257,821.2 |
| 7 | 1.2.1 УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ | 128,477.6 | 143,704.0 |
| 8 | 1.2.2 ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,628,742.1 | 3,114,117.2 |
| 9 | 1.2.2.02 Биет хөрөнгө | 1,421,421.8 | 2,873,796.8 |
| 10 | 1.2.2.03 Биет бус хөрөнгө | 207,320.4 | 240,320.4 |
| 11 | 1 НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2 | 4,963,152.0 | 6,390,077.4 |
| 12 | 2.1 НИЙТ ӨР ТӨЛБӨР | 13,069.1 | 11,627.3 |
| 13 | 2.1.1 БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 13,069.1 | 11,627.3 |
| 14 | 2.1.1.03 Өглөг | 13,069.1 | 11,627.3 |
| 15 | 2.2 ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 4,950,082.9 | 6,378,450.0 |
| 16 | 2.2.1 Засгийн газрын хувь оролцоо | 4,950,082.9 | 6,378,450.0 |
| 17 | 2.2.1.01 Засгийн газрын оруулсан капитал | 5,352,906.3 | 5,352,906.3 |
| 18 | 2.2.1.02 Өмч /төрийн/ /ТӨҮГ/ | 2,221.9 | 2,221.9 |
| 19 | 2.2.1.07 Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/ | 31,830.5 | 31,830.5 |
| 20 | 2.2.1.08 Хуримтлагдсан үр дүн | -488,364.1 | 940,003.0 |
| 21 | 2.2.1.09 Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 51,488.3 | 51,488.3 |
| 22 | 2 ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5 | 4,963,152.0 | 6,390,077.4 |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

(мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН | 4,312,197.5 | 6,012,872.2 |
| 2 | 1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 2,722,235.5 | 2,770,194.4 |
| 3 | 1.1.1.03.1 Орлогын албан татвар | 506,804.7 | 501,255.3 |
| 4 | 1.1.1.03.1.01 Хувь хүний орлогын албан татвар | 506,804.7 | 501,255.3 |
| 5 | 1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 16,889.1 | 18,807.1 |
| 6 | 1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 2,198,541.6 | 2,250,131.9 |
| 7 | 1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 428,690.7 | 3,242,677.9 |
| 8 | 1.1.1.04.2 Хөрөнгийн орлого | 1,743.2 | 0.0 |
| 9 | 1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 969,067.3 |
| 10 | 1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,161,271.3 | 0.0 |
| 11 | 1.1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 2,064,163.3 | 4,407,388.1 |
| 12 | 1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 2,064,163.3 | 4,407,388.1 |
| 13 | 1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,002,095.2 | 2,474,002.2 |
| 14 | 1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 725,584.4 | 861,045.8 |
| 15 | 1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 88,921.3 | 99,243.5 |
| 16 | 1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 250,842.4 | 299,493.5 |
| 17 | 1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 117,330.6 | 168,242.3 |
| 18 | 1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 47,356.1 | 101,667.7 |
| 19 | 1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 9,754.0 | 4,888.0 |
| 20 | 1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 379,902.4 | 492,171.6 |
| 21 | 1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 382,404.1 | 447,249.9 |
| 22 | 1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 62,068.1 | 1,933,385.9 |
| 23 | 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II) | 2,248,034.1 | 1,605,484.1 |
| 24 | 1.2.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 108,664.4 | 177,117.0 |
| 25 | 1.2 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V) | -108,664.4 | -177,117.0 |

| | | | |
|---|---|---|---|
| 26 | 1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII) | 2,139,369.8 | 1,428,367.1 |

## 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

(мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | 2024 оны 12-р сарын 31 | 2025 оны 12-р сарын 31 |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН | 4,157,907.8 | 4,292,863.7 |
| 2 | 1.1.1.1.03 ТАТВАРЫН ОРЛОГО | 2,722,235.5 | 2,770,194.4 |
| 3 | 1.1.1.1.03.1 Орлогын албан татвар | 506,804.7 | 501,255.3 |
| 4 | 1.1.1.1.03.3 Хөрөнгийн албан татвар | 16,889.1 | 18,807.1 |
| 5 | 1.1.1.1.03.8 Бусад татвар, төлбөр, хураамж | 2,198,541.6 | 2,250,131.9 |
| 6 | 1.1.1.1.03.8.01 Бусад нийтлэг төлбөр, хураамж | 67,223.9 | 145,084.2 |
| 7 | 1.1.1.1.03.8.02 Газрын төлбөр | 15,311.2 | 9,838.9 |
| 8 | 1.1.1.1.03.8.03 Байгалийн нөөц ашигласны төлбөр | 2,116,006.5 | 2,095,208.8 |
| 9 | 1.1.1.1.04 ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 274,401.0 | 1,522,669.3 |
| 10 | 1.1.1.1.04.1 Нийтлэг татварын бус орлого | 272,657.8 | 262,029.6 |
| 11 | 1.1.1.1.04.2 Хөрөнгийн орлого | 1,743.25 | 0.0 |
| 12 | 1.1.1.1.04.3 Тусламжийн орлого | 0.0 | 969,067.3 |
| 13 | 1.1.1.1.04.4 Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 0.0 | 291,572.5 |
| 14 | 1.1.1.1.05 ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 1,161,271.3 | 0.0 |
| 15 | 1.1.1.2 НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 1,646,817.4 | 3,846,444.8 |
| 16 | 1.1.1.2.01 УРСГАЛ ЗАРДАЛ | 1,646,817.4 | 3,846,444.8 |
| 17 | 1.1.1.2.01.1 БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,584,749.3 | 1,913,058.9 |
| 18 | 1.1.1.2.01.1.01 Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 868,303.1 | 1,050,487.3 |
| 19 | 1.1.1.2.01.1.02 Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 121,415.5 | 99,243.5 |
| 20 | 1.1.1.2.01.1.03 Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 259,688.0 | 321,044.5 |
| 21 | 1.1.1.2.01.1.04 Хангамж, бараа материалын зардал | 70,953.15 | 64,255.88 |
| 22 | 1.1.1.2.01.1.06 Эд хогшил, урсгал засварын зардал | 53,935.7 | 80,165.7 |
| 23 | 1.1.1.2.01.1.07 Томилолт, зочны зардал | 9,754.0 | 4,888.0 |
| 24 | 1.1.1.2.01.1.08 Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 177,556.6 | 271,890.6 |
| 25 | 1.1.1.2.01.1.09 Бараа үйлчилгээний бусад зардал | 23,143.3 | 21,083.5 |
| 26 | 1.1.1.2.01.4 УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 62,068.1 | 1,933,385.9 |
| 27 | 1.1.1 ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 2,511,090.4 | 446,418.9 |
| 28 | 1.1.2.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН | 589,333.8 | 1,265,868.6 |
| 29 | 1.1.2.2.01 ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 589,333.8 | 1,265,868.6 |
| 30 | 1.1.2.2.01.1 Дотоод эх үүсвэрээр | 589,333.8 | 1,265,868.6 |
| 31 | 1.1.2 ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | -589,333.8 | -1,265,868.6 |
| 32 | 1.1.3.2 ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 0.0 | 125,460.0 |
| 33 | 1.1.3 САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | 0.0 | -125,460.0 |
| 34 | 1.1 НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII) | 1,921,756.6 | -944,909.7 |
| 35 | 1.2 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 684,260.9 | 2,606,017.6 |
| 36 | 1 Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 2,606,017.6 | 1,661,107.8 |

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

(мянган төгрөгөөр)

| № | Дансны нэр, төрөл | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн | Нийт цэвэр хөрөнгө /өмч |
|---|---|---|---|
| 1 | 1.1.1.1.1.1 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 2,812,482.7 | 2,812,482.7 |
| 2 | 1.1.1.1.1.2 Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | -1,769.5 | -1,769.5 |
| 3 | 1.1.1.1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 2,810,713.2 | 2,810,713.2 |
| 4 | 1.1.1.1.7 Тайлант үеийн үр дүн | 2,139,369.8 | 2,139,369.8 |
| 5 | 1.1.1.1 2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 4,950,082.9 | 4,950,082.9 |
| 6 | 1.1.1 2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл | 4,950,082.9 | 4,950,082.9 |
| 7 | 1.1 Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 4,950,082.9 | 4,950,082.9 |
| 8 | 1.7 Тайлант үеийн үр дүн | 1,428,367.1 | 1,428,367.1 |
| 9 | 1 2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл | 6,378,450.1 | 6,378,450.1 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

(мянган төгрөг)

| Дансны код | Дансны нэр, төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 8,319,729.9 | 6,803,004.1 | (1,516,725.8) | 81.8 |
| 11 | Татварын орлого | 2,107,060.2 | 2,770,194.4 | 663,134.2 | 131.5 |
| 110 | Орлогын албан татвар | 443,517.9 | 501,255.3 | 57,737.4 | 113.0 |
| 1100 | Хувь хүний орлогын албан татвар | 443,517.9 | 501,255.3 | 57,737.4 | 113.0 |
| 110001 | Цалин, хөдөлмөрийн хөлс, тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого | 358,877.9 | 407,669.9 | 48,792.0 | 113.6 |
| 110002 | Үйл ажиллагааны орлого | 6,000.0 | 5,946.9 | (53.1) | 99.1 |
| 110003 | Хөрөнгийн орлого | 30,000.0 | 35,368.7 | 5,368.7 | 117.9 |
| 110004 | Хөрөнгө борлуулсны орлого | 1,140.0 | 500.0 | (640.0) | 43.9 |
| 110008 | Шууд бус орлого | 47,500.0 | 51,769.8 | 4,269.8 | 109.0 |
| 113 | Хөрөнгийн албан татвар | 18,046.5 | 18,807.1 | 760.6 | 104.2 |
| 113001 | Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар | 5,000.0 | 5,987.6 | 987.6 | 119.8 |
| 113002 | Бууны албан татвар | 3,100.0 | 2,890.0 | (210.0) | 93.2 |
| 113004 | Малд ногдуулах албан татвар | 9,946.5 | 9,929.5 | (17.0) | 99.8 |
| 118 | Бусад татвар, төлбөр, хураамж | 1,645,495.8 | 2,250,131.9 | 604,636.1 | 136.7 |
| 1180 | Бусад нийтлэг төлбөр, хураамж | 13,960.0 | 145,084.2 | 131,124.2 | 1,039.3 |
| 118001 | Улсын тэмдэгтийн хураамж | 5,000.0 | 136,190.2 | 131,190.2 | 2,723.8 |
| 118006 | Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр | 1,000.0 | 1,000.0 | - | 100.0 |
| 118009 | Хог хаягдлын үйлчилгээний хураамж | 7,960.0 | 7,894.0 | (66.0) | 99.2 |
| 1181 | Газрын төлбөр | 10,000.0 | 9,839.0 | (161.0) | 98.4 |
| 118101 | Газрын төлбөр | 10,000.0 | 9,839.0 | (161.0) | 98.4 |
| 1182 | Байгалийн нөөц ашигласны төлбөр | 1,621,535.8 | 2,095,208.8 | 473,673.0 | 129.2 |
| 118201 | Ойн нөөц ашигласны төлбөр | 1,594,412.8 | 2,067,425.3 | 473,012.5 | 129.7 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 118202 | Ан амьтны нөөц ашигласны төлбөр | 25,423.0 | 25,483.7 | 60.7 | 100.2 |
| 118203 | Ус, рашааны нөөц ашигласны төлбөр | 200.0 | 244.7 | 44.7 | 122.4 |
| 118204 | Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөр | 1,500.0 | 2,055.0 | 555.0 | 137.0 |
| 12 | Татварын бус орлого | 6,212,669.7 | 4,032,809.7 | (2,179,860.0) | 64.9 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 44,100.0 | 73,467.6 | 29,367.6 | 166.6 |
| 120003 | Торгуулийн орлого | 5,000.0 | 9,849.0 | 4,849.0 | 197.0 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/ | 35,000.0 | 49,019.5 | 14,019.5 | 140.1 |
| 120010 | Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/ | 4,100.0 | 14,234.1 | 10,134.1 | 347.2 |
| 120005 | Түрээсийн орлого | - | 365.0 | 365.0 | |
| 121 | Хөрөнгийн орлого | 1,000.0 | - | (1,000.0) | - |
| 121001 | Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого | 1,000.0 | - | (1,000.0) | - |
| 122 | Тусламжийн орлого | 5,867,151.2 | 3,667,769.6 | (2,199,381.6) | 62.5 |
| 122003 | Аймаг нийслэлээс авсан татаас | 925,300.0 | 925,300.0 | - | 100.0 |
| 122004 | Сум дүүргээс авсан тэгшитгэл | - | - | - | |
| 122005 | Төсвөөс санхүүжих | 4,941,851.2 | 2,742,469.6 | (2,199,381.6) | 55.5 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 300,418.5 | 291,572.5 | (8,846.0) | 97.1 |
| 123002 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого | 300,418.5 | 291,572.5 | (8,846.0) | 97.1 |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 5,867,610.6 | 4,987,036.3 | (880,574.3) | 85.0 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,056,789.4 | 3,820,608.7 | (236,180.7) | 94.2 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,112,219.2 | 1,887,222.8 | (224,996.4) | 89.3 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 931,720.4 | 861,955.5 | (69,764.9) | 92.5 |
| 210101 | Үндсэн цалин | 495,138.2 | 449,125.0 | (46,013.2) | 90.7 |
| 210102 | Нэмэгдэл | 406,222.2 | 363,594.9 | (42,627.3) | 89.5 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 6,360.0 | 25,235.6 | 18,875.6 | 396.8 |
| 210104 | Урамшуулал | 24,000.0 | 24,000.0 | - | 100.0 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 110,406.8 | 99,243.5 | (11,163.3) | 89.9 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 73,138.1 | 65,820.2 | (7,317.9) | 90.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,317.1 | 8,356.0 | (961.1) | 89.7 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,658.6 | 4,177.8 | (480.8) | 89.7 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,658.6 | 4,177.8 | (480.8) | 89.7 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 18,634.4 | 16,711.7 | (1,922.7) | 89.7 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 315,538.1 | 310,891.2 | (4,646.9) | 98.5 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 82,083.0 | 77,882.2 | (4,200.8) | 94.9 |
| 210302 | Түлш, халаалт | 221,426.1 | 221,426.1 | - | 100.0 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 12,029.0 | 11,582.9 | (446.1) | 96.3 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 63,204.6 | 43,190.0 | (20,014.6) | 68.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 9,800.0 | 6,262.1 | (3,537.9) | 63.9 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 32,200.0 | 22,561.3 | (9,638.7) | 70.1 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,920.0 | 3,987.0 | (933.0) | 81.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 740.0 | - | (740.0) | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 4,844.6 | 4,844.6 | - | 100.0 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,700.0 | 5,535.0 | (5,165.0) | 51.7 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 58,365.7 | 55,165.7 | (3,200.0) | 94.5 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,200.0 | - | (1,200.0) | - |
| 210602 | Тавилга | 2,000.0 | - | (2,000.0) | - |
| 210604 | Урсгал засвар | 55,165.7 | 55,165.7 | - | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 11,800.0 | 4,888.0 | (6,912.0) | 41.4 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,800.0 | 4,888.0 | (6,912.0) | 41.4 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 257,435.1 | 189,067.7 | (68,367.4) | 73.4 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 252,763.7 | 186,431.3 | (66,332.4) | 73.8 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 1,152.0 | - | (1,152.0) | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 500.0 | 193.4 | (306.6) | 38.7 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,500.0 | 2,189.0 | (311.0) | 87.6 |
| 210807 | Газрын төлбөр | 519.4 | 254.0 | (265.4) | 48.9 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 363,748.5 | 322,821.3 | (40,927.2) | 88.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 363,748.5 | 322,821.3 | (40,927.2) | 88.7 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 32,786.0 | 21,601.7 | (11,184.3) | 65.9 |
| 2131 | Засгийн газрын урсгал шилжүүлэг | 32,786.0 | 21,601.7 | (11,184.3) | 65.9 |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | 32,786.0 | 21,601.7 | (11,184.3) | 65.9 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 32,786.0 | 21,601.7 | (11,184.3) | 65.9 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 16,286.0 | 5,601.7 | (10,684.3) | 34.4 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 16,500.0 | 16,000.0 | (500.0) | 97.0 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 1,684,977.4 | 1,040,667.5 | (644,309.9) | 61.8 |
| 223001 | Бусад хөрөнгө | 1,684,977.4 | 1,040,667.5 | (644,309.9) | 61.8 |
| 23 | ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ | 125,843.8 | 125,460.0 | (383.8) | 99.7 |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 125,843.8 | 125,460.0 | (383.8) | 99.7 |
| 8 | ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ | 2,452,119.3 | (926,201.8) | (3,378,321.1) | (37.8) |
| 9 | АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | (2,452,119.3) | 926,201.8 | 3,378,321.1 | (37.8) |
| 7 | Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт | (2,452,119.3) | 926,201.8 | 3,378,321.1 | (37.8) |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 2,477,562.8 | 2,477,562.8 | |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 1,553,360.6 | 1,553,360.6 | |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

(мянган төгрөг)

| Дансны код | Дансны нэр, төрөл | Өмнөх он | Тайлант он | Зөрүү |
|---|---|---|---|---|
| 1 | НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН | 42,508.0 | 41,767.7 | (740.3) |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 42,508.0 | 41,767.7 | (740.3) |
| 122 | Тусламжийн орлого | 42,508.0 | 41,767.7 | (740.3) |
| 1221 | Хандив тусламж /дотоод/ | 42,508.0 | 41,767.7 | (740.3) |
| 12213 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 42,508.0 | 41,767.7 | (740.3) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 350014 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 42,508.0 | 41,767.7 | (740.3) |
| II | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 42,508.0 | 41,767.7 | (740.3) |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 35,801.1 | 41,767.7 | 5,966.6 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 6,706.9 | 41,767.7 | 35,060.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,452.4 | 694.0 | (758.4) |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,452.4 | 694.0 | (758.4) |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | | 25,000.0 | 25,000.0 |
| 210604 | Урсгал засвар | | 25,000.0 | 25,000.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 5,254.5 | 16,073.7 | 10,819.2 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,254.5 | 16,073.7 | 10,819.2 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **35,801.1** | - | (35,801.1) |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **35,801.1** | - | (35,801.1) |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 35,801.1 | - | (35,801.1) |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд сумын орон нутгийн ерөнхий орлогын данс болон харьяа төсвийн 2 байгууллага, орон нутгийн 2 тусгай сан, “Нарс шинэсэн төгөл” сум дундын ойн ангийн нийт 5 санхүүгийн тайлан, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн орон нутгийн төсвөөс авсан санхүүжилтийн хүрээнд гарсан мөнгөн гүйлгээний тайлан, орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн тайланг  нэгтгэснээс сумын ЗДТГ-ын санхүүгийн тайланд дүгнэлт гаргаж, бусад байгууллага, тусгай сангийн  санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлын хэсэгчлэн гүйцэтгэсэн.

Цагаан-Үүр сумын ЗДТГ-ын санхүүгийн тайлангийн аудитаар “Зөрчилгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд хийсэн аудитаар 182.0 сая төгрөгийн 1 алдааг залруулж, нийт 63.3 сая төгрөгийн 3 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгах 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төлөвлөлт, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой нийт 43.7 сая төгрөгийн 2 зөрчил илрүүлж, илэрсэн зөрчлийг арилгах  2 зөвлөмж хүргүүлж байна.

### 3.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал**

1.1. <u>Илрүүлэлт:</u>

Шинээр байгуулагдсан Бүтээлч үүр ХХК-ийн 0.03 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн байдлын тайланд нэгтгээгүй байна. Энэ нь Сангийн сайдын 341 дүгээр тушаалаар батлагдсан “Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын 3.4 “Төсвийн ерөнхийлөн захирагч нь санхүүгийн тайлагналын зорилгоор хяналтад байгаа төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагын санхүүгийн тайланг, орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нь орон нутгийн өмчит аж ахуйн нэгжийн санхүүгийн тайланг тус тус хүлээн авч нэгтгэлдээ бүрэн хамруулна” заалт, санхүүгийн тайлангийн “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2. <u>Өгсөн зөвлөмж:</u>

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайланг бүрэн хамруулж нэгтгэсэн тайлан тусгаж байх

**2. Төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлтэй холбоотой асуудал**

2.1 Илрүүлэлт:

Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг 6.3 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг 4.1 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1.*"Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх"* гэсэн заалттай нийцэхгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж:

Улс орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогыг бодитой төлөвлөж, нэр төрлөөр ханган биелүүлж ажиллах.

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс Залруулсан | | Үүнээс Залруулаагүй | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Харьяа байгууллагуудын алдаа** | | | | | | | | | | | | |
| Засаг даргын Тамгын газар | 1 | 182.0 | | | 1 | 182.0 | 1 | 182.0 | | | | |
| **Дүн** | **1** | **182.0** | | | **1** | **182.0** | **1** | **182.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шинээр байгуулагдсан Бүтээлч үүр ХХК-ийн 0.03 сая төгрөгийн хөрөнгө, 43.7 сая төгрөгийн орлого, зардлыг санхүүгийн байдлын тайланд нэгтгээгүй байна. | 1 | 43.7 | | | | | 1 | 43.7 |
| Улсын төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг 4.7 сая төгрөгөөр, аймгийн төсөвт төвлөрүүлэх татварын орлогын төлөвлөгөөг 6.3 сая төгрөгөөр дутуу биелүүлсэн байна. | 1 | 11.0 | | | | | 1 | 11.0 |
| **Дүн** | **2** | **54.7** | | | | | **2** | **54.7** |
| Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газар | 1 | 5.7 | | | 1 | 5.7 | | |
| **Дүн** | **1** | **5.7** | | | **1** | **5.7** | **2** | **50.0** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/сая төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс Төлбөрийн акт | | Үүнээс Албан шаардлага | | Үүнээс Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Харьяа байгууллагуудын зөрчил | | | | | | | | |
| Цагаан-Үүр сумын Засаг даргын Тамгын газар | 2 | 57.5 | | | | | 2 | 57.5 |
| Дүн | **2** | **57.5** | | | | | **2** | **57.5** |